

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Д/ Д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт |
|---------|--|--|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | <p>1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, телезохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх</p> <p>1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулах</p> <p>1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах</p> | <p>Албан хаагчдыг авлига авах, өгөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор постер хийж, ГЕГ-ын албан ёсны цахим хуудаст байршуулсан. Мөн харьяа гаалийн газар, хороодод дотоод сүлжээгээр мэдэгдсэний дагуу 18 гаалийн газар, хороо албан ёсны цахим хуудаст байршуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 19 төрлийн постер, 14 төрлийн видео шторкийг ГЕГ-ын харьяа 18 гаалийн газар хороодод хүргүүлсэн. Мөн гаалийн байгууллагын цахим хуудас /www.customs.gov.mn/-нд болон Гаалийн ерөнхий газрын 1-р давхрын цахим мэдээллийн дэлгэцэнд байршуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс улсын хэмжээнд зохион байгуулсан иргэн, хувь хүний зан суртахуунд тулгуурлан нийгэмд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд бэлтгэсэн “Тангараг” нэртэй богино хэмжээний видео зохиомжийг Улаанбаатар хот дахь гаалийн газарт хийхэд удирдлагын зүгээс дэмжин хамтарч ажилласан бөгөөд уг аяны хүрээнд бэлтгэсэн видео зохиомжуудыг ГЕГ-ын цахим хуудасны нүүр хэсэгт байршуулж олон нийтэд хүргэсэн.</p> <p>Авлигаас ангид байхад байгууллагын соёл , хамт олны уур амьсгал хэрхэн нөлөөлдөг талаар “ЗӨВ ЗАН ҮЙЛИЙГ БАЙГУУЛЛАГАДАА ХЭВШҮҮЛБЕ!” аян өрнүүлэхийг уриалсан болно.</p> <p>“Гаалийн байгууллагын хувьд Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга ёсыг эрхэмлэн ажиллах арга хэмжээг 2021 оны хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд багтааж, програмд оруулсан. Мөн Гаалийн байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу боловсруулж, гаалийн ерөнхий газрын даргаар 2021-02-01-ний өдөр батлуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулж, ГГХ-дод албан бичгээр, ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгуулагуудад дотоод зурвасаар хүргүүлж ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Дээрхи төлөвлөгөөний хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс</p> |

| | | | |
|----|---|--|--|
| | | | хөгжил дэвшилд"-110" мэдээллийн самбарыг АТГ-аас хүлээн авч Гаалийн ерөнхий газрын 1-р давхрын хүлээлгийн танхимд байршуулсан. |
| 2. | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах | 2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлэх | АТГ-аас цахим шуудангаар ирүүлсэн хүсэлтийн дагуу төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтад хамрагдаж байгаагүй албан хаагчдын судалгааг гаргуулж, 11 албан хаагчийн мэдээллийг нэгтгэн тус газарт 2021 оны 09 сарын 29-ний өдөр цахим шуудангаар хүргүүлсэн. Мөн АТГ-аас ирүүлсэн сургалтын зохион байгуулалттай холбоотой мэдээллийг ГГХ-дод цахимаар хүргүүлэв. |
| | | 2.2.АТГ-аас халдварт цар тахал /Ковид 19/-аас урьдчилан сэргийлэх нөхцөлд зохион байгуулах авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах | 2.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хариуцдаг албан тушаалтнуудад зориулсан сургалтад 1, Авлигын эсрэг анхан шатны сургалтад харьяа гаалийн газар, хороодын албан хаагчид 129, Төрийн албаны удирдах албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг давтан сургалтад 1, Яам, агентлагуудын хуулийн асуудал эрхэлсэн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг сургалтад 1, Агентлагуудын харьяа байгууллагын хуулийн асуудлаар хариуцсан албан хаагчдад зориулсан авлигын эсрэг сургалтад 3, Авлигын шалтгаан нөхцөл, хор уршиг, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, Авлигын гэмт хэргийн талаарх шинэ зохицуулалт, анхаарах асуудал сэдэвт сургалтуудад 152 албан хаагч, нийт 287 албан хаагч хамрагдсан. |
| | | 2.3.Гаалийн харилцаанд оролцогчдод авлига, түүний хор холбогдлын талаар таниулах, мэдээлэл өгөх ажил зохион байгуулах | 2.3. ХМССТ-өөс 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр гаалийн улсын ахлах байцаагч Буянт-Ухаа дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч нарт зориулсан давтан сургалтад "Гаалийн улсын байцаагчийн ёс зүй, авлигаас ангид байх" талаар 4 цагийн хичээл бэлтгэж, заасан. 11 дүгээр сарын 11-нд Удирдлагын академийн багш Н.Цолмонтуяа "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж нийт 160 гаалийн ажилтан, албан хаагч тус тус хамрагдсан. -Гаалийн улсын байцаагч нарт зориулж Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хуулиудад тусгагдсан төрийн албан хаагчийн сахилга, ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтуудыг тусгасан гарын авлагыг эмхтгэн бэлтгэж тараасан. -"Авлигаас ангид нийгмийн төлөө хамтдаа" хандсан уриан дор гаалийн зуучлагч, тээвэрлэгч нарт зориулсан хууль тогтоомж, эрх үүргээр нь 3 төрлийн гарын авлага, зурагт хуудсыг бэлтгэн ажлын төв байр болон гаалийн хяналтын байгууллын цахим хуудаст болон мэдээллийн самбарт байршуулсан нь өндөржүүлсэн бэлэн байдлын үед заавал нүүр тулж уулзахгүйгээр хаанаас ч унших боломжийг бүрдүүлсэн. |
| 3 | Авлигатай тэмцэх | 3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авч хүргүүлсэн. Үүнд: |

| | | |
|--|--|---|
| <p>газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх</p> | <p>3.2.Мөрдөгчийн мэдэгдэл, 3.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах</p> | <p>1. Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатараас ирүүлсэн 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 05/1939 дугаартай тайлбар, нотлох баримт гаргуулах тухай албан бичгийн дагуу Б.Батгэрэлийн нэхэмжлэлтэй Гаалийн ерөнхий газрын даргад холбогдох захиргааны хэргийн шүүхийн шийдвэр түүнийг биелүүлэхгүй байгаа талаарх тайлбар болоод холбогдох баримтыг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01-1/495 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2. Авлигатай тэмцэх газрын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 03/1600 дугаартай албан бичгээр СШГГ-ын ГУБ Ц.Мөнхжаргалтай холбоотой хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, зөрчил арилгуулах талаар ирүүлсэнд 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01-1/512 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн ба 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн ГЕГ-ын даргын тушаалаар гаалийн албанаас чөлөөлөгдсөн.</p> <p>3. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 06/9981 дугаартай гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай 107 дугаартай "Мөрдөгчийн мэдэгдэл" -д зааснаар гаалийн улсын байцаагч, гаалийн улсын ахлах байцаагч, дарга нарын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэдэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, мэдээллэх, сургалт зохион байгуулах, албандаа хандах хандлага, итгэл үнэмшил, үнэлэмжийг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах, авлига, хээл хахууль өгөх, авах гэмт хэрэг болон бусад төрлийн гэмт хэргээс сэргийлэх сэргийлэх, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын хүлээх нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах зэрэг тодорхой ажлыг зохион байгуулж, хариу ирүүлэхийг мэдэгдсэн. Уг мэдэгдлийн хариуг 2021.10.25-ны 01-1/2642 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>4. Авлигатай тэмцэх газрын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 05/12304 дугаар албан бичгээр Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газрын Хэрэг бүртгэгч, гаалийн улсын ахлах байцаагч Н.Отгонбаяр, мөн тус гаалийн газрын гаалийн улсын байцаагч Б.Одонгэрэл нарт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт "ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал"-ыг бий болгохоос гадна мөн хуулийн 3.1.3 дахь заалтад заасан "ашиг сонирхлын зөрчил" үүссэн гэж үзжээ.</p> <p>Үүний дагуу Хүний нөөцийн хэлтсээс Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт заасны дагуу Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газрын Хэрэг бүртгэгч, гаалийн улсын ахлах байцаагч Н.Отгонбаяр, мөн тус гаалийн газрын гаалийн улсын байцаагч Б.Одонгэрэл нарын эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэвийг бууруулахгүйгээр өөр харьяа гаалийн газар хороодод шилжүүлэх, сэлгэн ажиллуулах ажлын</p> |
|--|--|---|

| | | | |
|--|--|--|--|
| | | | <p>байрны судалгааг гаргаж, Захиргааны ерөнхий тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу Авлигатай тэмцэх газрын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 05/12304 дугаар албан бичиг, ажлын байрны судалгаа зэргийг танилцуулан, сонсох ажиллагаа хийсний үндсэн дээр өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах талаар саналыг ГЕГ-ын ХНХ-т 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр хүргүүлж, холбогдох арга хэмжээ авсан талаар материалыг ХНХ-ээс ирүүлвэл Авлигатай тэмцэх газарт хүргүүлэхээр хүлээгдэж байгаа болно.</p> <p>Авлигатай тэмцэх газраас 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 06/6790 тоот албан бичгээр “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай” 74 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийг ирүүлсэн. Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газраас тус мөрдөгчийн мэдэгдлийн дагуу хэрэгжүүлсэн ажлын талаар 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01-2/1711 дугаар албан бичгээр хариуг хүргүүлж харьяа гаалийн газар хороодод 2021 оны 10 дугаар сарын 08 01-2/ 2479 албан бичгээр гаалийн газар хороодын дарга нарт чиглэл хүргүүлж дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>-Гаалийн улсын байцаагч нарын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж албан тушаалын шатлал бүрийн албан хаагч нар үүрэг хариуцлагаа дээшлүүлэн, тус бүр өөрт харьяалагдах доод шатны албан тушаалтнуудад тавих хяналтаа өндөрсгөн ажиллахыг үүрэг болгосон,</p> <p>-Гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарт албан үүрэгтээ хариуцлагатай хандан авлига ашиг сонирхлын зөрчлөөс анид байж гаалийн албаны нэр төрийг өндөрт өргөн, өргөсөн тангарагтаа үнэнч байхыг сануулан ГЕГ болон хууль хяналтын байгууллагаас өгсөн чиглэл, зөвлөгөөг Спарк болон байгуулга тус бүрийн facebook группээр дамжуулан танилцуулсан,</p> <p>-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын хэмжээнд авлига хүнд суртал үүсэх эрсдлийг бууруулж, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагааг эрчимжүүлэх, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулах талаар тодорхой арга хэмжээ авч, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдохгүй, хууль журмын дагуу ажиллаж байх талаар нийт албан хаагч нарт үүрэг чиглэл зөвлөгөө өгч баталгаа гаргуулан гарын үсэг зуруулсан.</p> <p>Мөн Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар байгууллыг хүлээх нийтлэг үүргийн дагуу гаалийн хяналтын бүсүүдэд ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах</p> |
|--|--|--|--|

| | | | |
|---|---|--|--|
| | | | <p>ажлыг Гаалийн зөрчилттэй тэмцэх хэрэг бүртгэх газраас зохион байгуулан ажиллаж байна</p> <p>-Албан хаагч нар өргөсөн тангарагтаа үнэнч байж, авлига, хээл хахуулиас ангид байхаа илэрхийлэн баталгаа гаргуулан гарын үсэг зурсан, хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг маягтын дагуу гаргуулан ажиллаж хэвшсэн.</p> <p>-Гаалийн улсын байцаагч нарт зориулж Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хуулиудад тусгагдсан төрийн албан хаагчийн сахилга, ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтуудыг тусгасан 545 ширхэгийг эмхтгэн бэлтгэж тараасан.</p> <p>-“Авлигаас ангид нийгмийн төлөө хамтдаа” хандсан уриан дор гаалийн зуучлагч, тээвэрлэгч нарч зориулсан хууль тогтоомж, эрх үүргээр нь 3 төрлийн гарын авлага, зурагт хуудсыг бэлтгэн ажлын төв байр болон гаалийн хяналтын байгууллын цахим хуудаст болон мэдээллийн самбарт байршуулсан нь өндөржүүлсэн бэлэн байдлын үед заавал нүүр тулж уулзахгүйгээр хаанаас ч унших боломжийг бүрдүүлсэн.</p> |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх | <p>4.1.Халдварт цар тахал (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх нөхцөлд Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, зохион байгуулсан аянд нэгдэх</p> <p>4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах</p> | <p>Гоц халдварт өвчний гамшгийн нөхцөл байдлын үед хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс хандив тусламж хүлээн авахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг чанд мөрдөх, дээд шатны удирдах төв байгууллагаас зөвшөөрөл авах, хандив тусламж, түүний зарцуулалтыг ил тод нээлттэй мэдээлэл чиглэлээр арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай харьяа Гаалийн газар хороодын дарга нарт Зөвлөмж хүргүүлж ажилласан.</p> <p>Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахалтай тэмцэх хууль тогтоомж, гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, иргэд, аж ахуйн нэгжид өгөх зөвлөмж, цахим хэлбэрт шилжсэн гаалийн үйлчилгээний мэдээлэл зэрэг цаг үеийн холбогдолтой нийт 63 мэдээ, мэдээллийг www.customs.gov.mn цахим хуудсанд, 165 пост мэдээллийг гаалийн байгууллагын Mongolian customs Facebook пэйж хуудас болон Монголын гааль twitter хуудсанд байршуулж олон нийтэд хүргэсэн байна.</p> <p>ГЕГ-ын Хуулийн хэлтэс нь ГЕГ-ын зохион байгуулалтын нэгжүүдээс болон төрийн болон төрийн бус байгууллагаас боловсруулан ирүүлсэн гэрээний төслийг авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаалийн болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянан үзэж гэрээний төсөлд талуудад давуу байдал үзүүлсэн гэрээний зүйл, заалтыг төслөөс хасуулах, өөрчлөх зэрэг арга хэмжээг авч ажилласан. 2021 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас болон Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн 11 нэгж, харьяа гаалийн 1</p> |

| | | | |
|---|--|--|--|
| | | | газраас боловсруулан ирүүлсэн гэрээний 55 төслийг хууль тогтоомжид нийцүүлэн хянан, төсөлд оруулах санал зөвлөмжийг тухай бүрт нь албан бичгээр, дотоод зурвасаар болон амаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн зарим үйл ажиллагааг цахим болгох | <p>1. Сангийн Сайдаас ГЕГ-ын удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын дагуу “Транспэрэнси интернэшнл байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт /индекс/-ийг бууруулах зорилго бүхий ажлын хэсгийн эрчимжүүлсэн арга хэмжээ”-г гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх 3 зорилтот 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд /chimidsuren_ch@mof.gov.mn/ хаягаар долоо хоног бүрийн пүрэв гараг бүр хүргүүлж байна.</p> <p>2. Гаалийн байгууллага Гаалийн цахим үйлчилгээний системийг (www.gaali.mn) 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдөр туршилтаар гаалийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Уг систем нэвтэрснээр гаалийн байгууллагаас үзүүлж буй гаалийн бүрдүүлэлт, төлбөр тооцоо, лавлагаа, тодорхойлолт, гадаад худалдааны барааны статистик мэдээлэл, барааны ангилал, тарифын мэдээлэл болон тусгай зөвшөөрөл зэрэг нийт 30 гаруй үйлчилгээг иргэн, ААН-үүдэд цахимаар авах боломжийг бүрдүүлж байна. Үүнд:</p> <p>ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ</p> <ul style="list-style-type: none"> • Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг • Шуудан илгээмжийн гаалийн мэдүүлэг • Экспорт/Импортын барааны гаалийн мэдүүлэг • Суудлын автомашины гаалийн мэдүүлэг <p>ТӨЛБӨР ТООЦОО</p> <ul style="list-style-type: none"> • Татвар хураамж төлөлт (ePayment, Social Pay, Qpay) • Татварын чөлөөлөлтийн хүсэлт цахимаар илгээх • Татварын буцаан олголт <p>ЛАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТ</p> <ul style="list-style-type: none"> • Гаалийн байгууллагад өртэй эсэх тодорхойлолт (иргэн) • Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа • Гаалийн зөрчлийн лавлагаа (иргэн) <p>БҮРТГЭЛ</p> <ul style="list-style-type: none"> • Гаалийн төв лабораторид магадлан шинжилгээ хийх хүсэлт • Барааны ангилал тодорхойлуулах • Хилээр нэвтрэх авто тээврийн хэрэгсэл бүртгүүлэх • Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн байгууллагад бүртгүүлэх <p>Энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Иргэн, ААН өөрсдөө гаалийн мэдүүлгээ нөхөн бичиж, бичиг баримтын цахимаар илгээснээр ЦАГ ХУГАЦАА, ЗАРДАЛ хэмнэх; -Экспорт/импортын мэдүүлгийн явцыг харах, ачаагаа хаана байгааг харах; |

| | | | |
|---|--|--|---|
| | | | <p>-Гаалийн татвар, хураамжийг шууд цахимаар төлөх;</p> <p>-Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт, гаалийн зөрчлийн лавлагаа, гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагааг гаалийн байгууллагаас тусгай эрх авахгүйгээр цахимаар шууд авах;</p> <p>-Гаалийн төв лабораторид магадлан шинжилгээ хийлгэх хүсэлт, гаалийн итгэмжлэл авах хүсэлт цахимаар илгээх;</p> <p>-Гаалийн байгууллагаас олгож буй энгийн болон тусгай зөвшөөрлийн мэдээллийг авч, үйлчилгээг цахимаар авах боломжуудыг бүрдүүлсэн.</p> <p>Энэхүү гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн шинэчлэл нь Монгол Улс ДХБ-н худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Гадаад худалдааны цахим нэг цонхыг бий болгох ажлын бэлтгэл болж байна.</p> <p>Гаалийн байгууллагаас олгодог Гаалийн байгууллагад өртэй эсэх тодорхойлолт, Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа, Гаалийн зөрчлийн лавлагаа-г цахимаар олгож байна. Өнөөдрийн байдлаар туршилтаар дээрхи бүх цэсийг ашиглаж байгаа бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 1-нээс албан ёсоор ашиглахаар төлөвлөж байна.</p> |
| 6 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | <p>6.1.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4,</p> <p>6.2.Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4,</p> <p>6.3.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах</p> | <p>-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг гаалийн байгууллагын цахим хуудас /www.customs.gov.mn/, шилэн дансны цахим хуудас болох /www.shilendans.gov.mn/ болон Гаалийн ерөнхий газрын 1 дүгээр давхарт байрлах ухаалаг дэлгэцэнд дараах мэдээллийг нийтэд ил тод байхаар байршуулсан болно.Үүнд:</p> <p>1.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /2021 он/,</p> <p>2.Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт /2021 он/,</p> <p>3.Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /2021 он/,</p> <p>4.Байгууллагын батлагдсан төсөв /2021 он/,</p> <p>5.Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл /2021 он/,</p> <p>6.Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /2021 он/,</p> <p>7.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /2021 он/,</p> <p>8.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл /2021 он/,</p> <p>9.Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр /2021 он/,</p> |

| | | | |
|--|--|--|--|
| | | | <p>10.Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /2021 он/, 11.Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /2021 он/, 12.Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /2021 он/, 13.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн /2021 он/.</p> <p>-Гаалийн байгууллагын улсын төсвийн орлогын болон гадаад худалдааны статистик, төсөв санхүү, худалдан авах үйл ажиллагааны мэдээлэл www.customs.gov.mn сайтад тухай бүр нийтлэгдэж байна. 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ашиглалтад орсон gaali.mn сайтад зарим мэдээлэл давхар нийтлэгдэх холбоос хийгдсэн болно. Цахим хуудасны “Гадаад худалдааны статистик мэдээлэл” цонхонд 2021 оны 1-11 дугаар сарын статистик мэдээний эмхтгэлийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, татаж авах боломжтой болсон.</p> <p>-Гадаад худалдааны нэгдсэн порталд Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан Бараа тээврийн хэрэгсэлтэй холбоотой батлагдсан 20 захиргааны хэм хэмжээний актыг гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн портал https://mongoliatradingportal.gov.mn/ -д байршуулсан.</p> |
|--|--|--|--|